



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 12/20

Улаанбаатар хот

Нийслэлийн 2017 оны төсөвт
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "б", 25 дугаар зүйлийн 25.1, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн 2017 оны төсөвт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.

1/ Нийслэлийн 2017 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/Мянган төгрөгөөр/

Хотын төсвийн нийт орлого		538,304,523.3
1. Төсвийн орлого		523,582,081.9
1.1 Татварын орлого		461,038,900.0
1.1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татвар		371,328,300.0
1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		- 25,420,000.0
1.1.3 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		47,700,000.0
1.1.4 Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар		24,500,000.0
1.1.5 Газрын төлбөрийн орлого		34,265,600.0
Үүнээс: Газрын төлбөр		30,500,000.0
Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт		3,765,600.0
1.1.6 Ус ашигласны төлбөр		3,630,000.0
1.1.7 Ойгоос мод ашигласны төлбөр		35,000.0
1.1.8 Нийслэл хотын албан татвар		5,000,000.0
1.2 Татварын бус орлого		62,543,181.9
1.2.1 Хувьцааны ногдол ашиг		1,100,000.0
1.2.2 Төрийн өмч түрээслүүлсний төлбөр		1,590,400.0
1.2.3 Төсөвт байгууллагын өөрийн орлого		10,059,881.9
1.2.4 Авто зам ашигласны төлбөр		11,072,900.0
1.2.5 Хүү торгуулийн орлого		23,890,000.0
1.2.6 Ангилагдаагүй бусад орлого		9,830,000.0
1.2.7 Өмч хувьчлалын орлого		5,000,000.0

1110101063